



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
НИЙСЛЭЛ ДЭХ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,  
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,  
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54,  
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2020.07.23 № 1275  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

НИЙСЛЭЛ, ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН  
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
СОНГУУЛЬД ОРОЛЦОХ  
ХӨГЖЛИЙН ХӨТӨЛБӨР НАМД

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн  
дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Орон нутгийн Хурлын сонгуульд оролцох Хөгжлийн хөтөлбөр намын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

**Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл**

Нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуульд оролцох нам, эвсэл, /бие даан нэр дэвшигч/ нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль болон “Алсын хараа-2050”-д нийцүүлэн боловсруулсан Нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилт, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцооны хамт ирүүлж, хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

**Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага нь нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуульд оролцох нам, эвсэл, болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдөө Төрийн аудит MNS 6817-1:2020 Тулгуур зарчим, Төрийн аудит MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, Төрийн аудит MNS 6817 8:2020 Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, “Алсын хараа-2050”, нийслэлийн 2021-2022 оны төсвийн төсөөлөл, Нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилт, холбогдох бусад байгууллагаас авсан мэдээллийг шалгуур болгосон.

**Дүгнэлт**

Хөгжлийн хөтөлбөр намын нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөр, түүнд орсон зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн

Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, "Алсын хараа-2050", Нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилт, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Хөгжлийн хөтөлбөр намын мөрийн хөтөлбөр /.....<sup>10</sup> хуудас/-ийг хавсаргав.

Хувийг Нийслэл, дүүргийн сонгуулийн хороонд

Хавсралт: <sup>10</sup> хуудастай

ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОРЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Б. НОМИНБААТАР



ХӨГЖЛИЙН ХӨТӨЛБӨР НАМ

# ХӨГЖЛИЙН ХӨТӨЛБӨР НАМЫН 2020-2024 ОНЫ СОНГУУЛИЙН МӨРИЙН ХӨТӨЛБӨР

УЛААНБААТАР ХОТ  
2020 он



## “ЧИНЭЭЛЭГ МОНГОЛ ХҮНИЙ ТӨЛӨӨ”

### ХӨГЖЛИЙН ХӨТӨЛБӨР НАМЫН 2020-2024 ОНЫ СОНГУУЛИЙН МӨРИЙН ХӨТӨЛБӨР

Монгол улсын эрхэм дээд баялаг бол Монгол хүн мөн. Монгол хүн төрийн хамгаалалтад байж хөгжлийн бодлогын зорилго бүр Монгол хүний сайн сайхан байдлыг дээшлүүлж эх орондоо элэг бүтэн эрх чөлөөтэй эд баялгаар дутагдах, гачигдах зүйлгүй, хариуцлагатай, эв зетэй байж урт насалж, удаан жаргуулахад чиглэгдэнэ.

#### Нэг. Нийгэм Улс төрийн зорилт

Нийгэм Улс төрийн зорилтод бодлогод хэрэгжүүлэхэд иргэдийн сэтгэлгээнд өөрчлөлт гаргах замаар оюун санаанд хувьсгал хийж нийгмийн хандлагыг зөв хөгжилд чиглүүлнэ

#### Хоёр. Эдийн засгийн бодлого

Ард иргэдэд

- Бэлэнчлэх бус бүтээх
- Хулгайлах бус хамгаалах
- Үрэлгэн бус хуримтлуулах
- Зарлагадах бус хэмнэх

дадлыг эзэмшүүлж эдийн засгийн боловсролыг дээшлүүлнэ.

Эдийн засгийн сахилга батыг сахиулж төрийн өмчийн зарцуулалтыг шилэн болгож үр дүнг татвар төлөгчдөд ил тод тайлагнадаг хэвшилд сургаж хариуцлага хяналтыг системд шилжүүлнэ.

Ингэснээр Монголчууд бусдын гар харахгүй ажиллаж амьдрах нөхцөл бүрдэнэ.

#### Гурав. Нийгэм, боловсрол, эрүүл мэнд, соёл урлаг, спортын хөгжлийн бодлого

Хүн төвтэй нийгмийн хөгжлийн цогц бодлого явуулж боловсролтой эрүүл чийрэг иргэдтэй болох. Хүн бүр хариуцлагатай байдаг суурь хүмүүжлийг балчир наснаас нь сургах.



**Дөрөв. Байгаль орчин, аялал жуулчлал, ногоон хөгжлийн бодлого**  
Ногоон эдийн засгийн бодлогыг төрөөс дэмжиж ард иргэдийн санаачлагыг өрнүүлж говийн ойжуулах бодлого явуулна.

**Тав. Аюулгүй байдал, гадаад харилцааны зорилт, хөтөлбөр**

Улс орны тусгаар тогтнол аюулгүй байдлыг төрийн анхаарлын төвд байлгаж

Гадаад орнуудтай найрсаг харилцааг бэхжүүлэх

**Зургаа. Аж үйлдвэржилтийн бодлого**

Байгалийн баялагт түшиглэсэн хүнд, хөнгөн, хүнсний үйлдвэрүүдийг бодлогоор хөгжүүлж Европын стандартыг нэвтрүүлж уул уурхайн эрдэс баялгийг боловсруулж экспорт-д гаргадаг болно.

**Долоо. Төсөв, мөнгөний бодлого**

Хэмнэлттэй сахилгатай төсөвтэй байж мөнгөний бодлогод шинэчлэл хийх


### **Нэг. Нийгэм, Улс төрийн бодлого**

1.1 Улс төрийн намууд төрд ноёрхох, ард иргэдээ намын харьяалал, нутаг ус, итгэл үнэмшил, сүсэг бишрэл, өмч хөрөнгөөр нь алагчлан зааглаж, хуваан өмчлөх үзэгдлийг эцэс болгож, нийгмийн талцал, хуваагдлын үндэс болсон улс төрийн намын хатуу гишүүнчлэлээс татгалзах;

1.2 Улс төрийн намууд төрийн өндөр албан тушаалд дэвшүүлж сонгосон, томилуулсан хүнийхээ төлөө хүлээх хариуцлагыг чангатгаж, төрийн албан хаагчид хээл хахууль авилгалын хэрэг үйлдсэн тохиолдолд хүлээх ял шийтгэлийг хүндрүүлж, төрийн албанд ажиллах эрхийг нь хязгаарлах;

1.3 Ард иргэдийг талцалд хүргэсэн нийгмийн амьдралын гол зангилаа асуудлууд түүний дотор Үндсэн хуулиар бүх ард түмний мэдэлд байхаар заасан асуудлыг ард түмний санал асуулгаар шийдэх ёсыг хэрэгжүүлж дэвшүүлэх ;

1.4 Жендэрийн эрх тэгш байдлыг хангах зорилгоор улс төрийн намууд бүх шатны сонгуульд нэр дэвших эмэгтэйчүүдийн квотыг 40%-иар тогтоох, төрийн албаны удирдах ажилтны 35-40%-ийг эмэгтэй нэр дэвшигчдээс сонгож байх;



1.5 Нүүдлийн соёл иргэншлийн үндсийн үндэс болсон малчин, мал, бэлчээрийн газар нутгийн дархлааг хангасан хууль эрх зүйн тогтвортой орчинг бий болгох;

## 2. Эдийн засгийн бодлого


Үндэснийхээ эдийн засгийн тусгаар тогтнолыг тууштай сахин бэхжүүлж, өргөн уудам нутаг дарааг, орчим хүч, түүхий эдийн засгийн нөөцөө түшиглэн инновацийн хүч, орчин үеийн тэргүүний техник технологийг ашиглаж өндөр үр ашигтай, тогтвортой, өөрийн хуримтлалаар өсөж хөгжих, өөрийгөө нөхөн тэтгэх, гадаад орчны өөрчлөлтөд дасан зохицох чадвартай макро төвшний эдийн засгийн нэгдсэн орон зайг бий болгоно.

2.1 Төрийн бодлогыг шинжлэх ухааны үндэслэлтэй төлөвлөж, шинжлэн судалж хэрэгжүүлдэг байх. Үүний тулд улс орны хөгжлийг төлөвлөх чадавхтай бодлого төлөвлөлтийн тогтолцоог бүрдүүлэх. Үндэсний эдийн засгийн бодлого, хэтийн төлөвийг тодорхойлох, төсөөлөхдөө дараах зарчмуудыг баримтлах

- Хүний хөгжил
- Эв зохицолтой хөгжил
- Тэнцвэртэй хөгжил
- Ногоон хөгжил
- Хуримтлалтай хөгжил
- Хөрш орнуудтай хорших хөгжил

2.2 Эдийн засгийн, эрх зүйн орчинг бүхэл цогцоор дараахь шаардлагуудад нийцүүлэн төгөлдөржүүлэн хэрэгжүүлэх, бүтцийг шинэчлэх,


- Эдийн засгийн уналтыг зогсоох, тогтворжуулах, өсөлтийг хангах цогц бодлого хэрэгжүүлж, эдийн засгийн өсөлтийн жилийн дундаж хурдцыг нэмэгдүүлэх
- Олон улсын стандартад нийцсэн өндөр хөгжил бүхий банк, санхүү, даатгал, хөрөнгө оруулалтын сан, хөрөнгийн зах зээлийн үйлчилгээний тогтолцоог эрчимтэй хөгжүүлж хууль эрх зүйн орчинг нь улам нээлттэй, ил тод хяналт зохицуулалттай болгох;



- Орон нутгийн сонгуулийг намаас дэвшүүлдэггүй иргэд өөрснөө дэвшүүлдэг болгох хуульд өөрчлөлт оруулах
- Эдийн засгийн чөлөөт бүсийг жинхэнэ утгаар нь бүрдүүлж газар нутгийг нь тэлж, эдийн засгийн чөлөөт бүсийн хуулийг сонгодог утгаар гаргаж хэрэгжүүлэх;
- Үндэсний эдийн засгийн тусгаар тогтнол, аюулгүй байдал, тогтвортой байдлыг хэрэгжүүлэх, Төрийн бодлогын нэгдмэл байдлыг хангаж, эдийн засгийг улс төрийн нам, фракц, нам дамнасан бүлэглэлийн "улс төрийн барьцаа"-наас салгах
- Төр, хувийн хэвшлийн үр ашигтай хамтын ажиллагааны тогтвортой орчинг бүрдүүлэх;
- Гадаадын хөрөнгө оруулагчдад тавих шаардлага, хамтарч ажиллах гэрээ хэлэлцээрүүдэд үндсэн хууль бусад хуулийг чанд мөрдөж улс орныхоо эрх ашгийг тууштай хамгаалах чадавх бүрдүүлэх;

2.3 Үндэсний эдийн засгийн бүтцийг нягтруулж, түлш, шатахуун, эрчим хүчний хэрэгцээг дотоодын үйлдвэрлэлээр бүрэн хангаж, нүүрс-хими, нефть-хими, өнгөт болон хар төмөрлөг, техник тоног төхөөрөмжийн салбарт өндөр технологи бүхий бага, дунд оврын үйлдвэрүүдээр эх орны түүхий эдийг боловсруулахыг дэмжсэн бодлого явуулах;

- Эрчим хүч импортлогч орноос экспортлогч орон болох;
- Эрчим хүчний дэвшилтэд технологийг нэвтрүүлж Орон нутагт сум дундын хэрэглээг хангах эко цахилгаан станц барих бодлогыг дэмжиж хэрэгжүүлэх;
- Олборлолт - Экспортын чиг хандлагатай уул уурхайн салбарыг Олборлолт - Боловсруулалт - Экспортын чиг хандлагатай болгон өөрчлөх;
- Эх орныхоо эрдэс түүхий эдийн баялгийг ариг гамтай, байгаль экологид хор хөнөөл учруулахгүйгээр олборлож, хамгийн үр ашигтай, хөрөнгө оруулалтаа богино хугацаанд нөхөж, үр огоожоо өгөх технологийн шатанд хүртэл боловсруулж, дотоод хэрэгцээгээ бүрэн хангаж, экспортын тогтвортой нөөц, эх үүсвэр бүрдүүлэх;



- Санхүүжүүлэх олон улсын банк, санхүүгийн байгууллага, гадаадын хөрөнгө оруулагчаа олсон нөхцөлд дундаж хүчин чадалтай өнгөт болон хар төмөрлөгийн үйлдвэр, ховор металлын үйлдвэр, химийн үйлдвэр, нефть боловсруулах үйлдвэр барихад зориулан төсөл хэрэгжүүлэх төр, хувийн хэвшлийн байгууллагуудад 10-15 жилийн хугацаатай баталгааг төрөөс гаргах механизмыг боловсруулж хэрэгжүүлэх;

2.4 Мал аж ахуй, газар тариалангийн үйлдвэрлэлээр ард иргэдийнхээ хүнсний хэрэгцээг генийн өөрчлөлтгүй, экологийн цэвэр хүнсний бүтээгдэхүүнээр хангаж, экспортлох хэмжээнд хүртэл тэтгэн хөгжүүлж, малчид, тариаланчдыг үнийн хэт алдагдалтай өөрчлөлт, зээлийн өрийн дарамтаас хамгаалах бодлого хэрэгжүүлэх;

- Дэм дэмэндээ хөдөлгөөн аймаг сумын төв, хот суурин газрын гэр хороололд өрхийн бичил үйлдвэрүүдийг хөгжүүлнэ.

2.5 Улс орны нийгэм эдийн засгийн хөгжлийн хэрэгцээг бүрэн дүүрэн хангаж, дотоод зах зээлээ эзлэх хүчин чадал, технологи бүхий барилгын материал, барилга үйлдвэрлэлийн цогцолборыг хөгжүүлэх;

2.6 Орон зайн хувьд алслагдмал байгаа Байгалийн нөөц баялгийг эдийн засгийн эргэлтэд оруулах, төвийн бүсэд байгаа боловсруулах үйлдвэрүүдэд нийлүүлэх хүдрийн тээвэрлэлтийн зардлыг бууруулах, хөрш хоёр орны ачаа эргэлтийг нэмэгдүүлэх, нэвтрүүлэх чадварыг дээшлүүлэх зорилгоор хамгийн дөт богино замаар европын хэсэгтэй холбохын тулд баруун бүсийн төмөр замын төслийг хэрэгжүүлэх олон улсын хөрөнгө оруулагч, сонирхогч талуудтай хамтран улсын төсөвт хүндрэл учруулахгүйгээр үндэсний хөрөнгө оруулагчид болон гадаад түншлэлийн харилцан ашигтай хамтын ажиллагаагаар хэрэгжүүлэх;

### **Гурав. Нийгэм, боловсрол, эрүүл мэнд, соёл урлаг, спортын хөгжлийн бодлого**

3.1 Боловсролын салбарын бүх шатны сургалтын хөтөлбөрийг орчин цагийн шинжлэх ухааны боловсрол олгох шаардлагад нийцүүлэн сайжруулж Монгол бичиг, кирилл бичиг эзэмших "Хос бичигтэн", гадаад хэл эзэмших "Хос хэлтэн" хотолборийг хэрэгжүүлнэ.



- Хүүхэд, залуучуудын эх хэлний мэдлэгийг сайжруулах шаардлагын үүднээс 2021 оноос эхлэн их дээд сургуулийн элсэлтийн шалгалтын онооны 25 хувийг Монгол бичиг, Монгол хэлний найруулга, зөв бичих дүрмийн хичээлээр тооцож байх журамд шилжих;
- 2021 оноос эхлэн төрийн албанд ажиллах ажилтнуудаас Монгол бичгийн шалгалт авдаг болох. Төрийн албанд тэнцэх босго оноог 90 болгох;
- 2024 оноос Монгол бичгийг төрийн албаны ёсны бичиг болгох;
- Үндэсний их дээд сургуулиудын сургалтын стандартыг олон улсын хүлээн зөвшөөрөх төвшинд тогтоох, сургалт, сорилт-туршилтын лаборатори судалгаа шинжилгээний баазтай байх шаардлагыг үндэсний стандарт болгон мөрдүүлэх

3.2 Их спорт, нийтийн биеийн тамирыг харилцан уялдаатай хөгжүүлж, Олимпийн наадамд тамирчидаа бэлтгэх асуудал төрийн анхааралд байлгана;

- Сум орон нутагт спорт тэмцээнийг зохион байгуулах, хүүхэд залуучууд болон иргэдийг чөлөөт цагаа биеийн тамирт зарцуулах боломжийг нэмэгдүүлэх
- Сум орон нутгууд хоорондоо уралдаан тэмцээнийг сар улирлаар зохион байгуулах боломжийг бүрдүүлж, хүүхэд залуучуудыг сум дундын болон аймаг дүүргийн тэмцээнд оролцох идэвхийг нэмэгдүүлэх
- Багш дасгалжуулагчдын ялангуяа анхны багш, бэлтгэл хангагчдын үнэлэмжийг дээшлүүлнэ;
- “Зөв хөгжилд хамтдаа” аяныг дэмжиж оюуны хувьсгал хийх

### **Дөрөв . Байгаль орчин, аялал жуулчлал, ногоон хөгжлийн бодлого**

4.1 Байгаль орчноо хамгаалан тэтгэж, хүрээлэн буй орчныг эрүүлжүүлэх бодлогыг шинэ шатанд гаргана.

- Улаанбаатар хот болон төв суурин газруудыг агаар, хөрс, усны бохирдлоос цэвэрлэх цогц хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- Говь, талын бүс нутагт ундны усыг аж ахуйн зориулалтаар хэрэглэхийг багасгахад хүчтэй түлхэц өгөх эдийн засаг, эрх зүйн орчин бүрдүүлнэ.




- Улаанбаатар хот, бусад томоохон хот суурин газруудын цэвэрлэх байгууламж, хог хаягдлыг устгах, боловсруулах технологи, хүчин чадлыг олон улсын шилдэг жишигт хүргэж, хяналтыг тогтмолжуулна.
- Цөлжилт эрчимтэй явж буй нутгуудад мал сүргийн бүтэц, маллагааны технологийг экологийн дарамт хамгийн бага байх шаардлагад нийцүүлэн зохицуулна.
- Ховордсон ан амьтан, ургамлыг уугуул нутагт нь буцаан үржүүлэх цогц арга хэмжээ авч, уул усыг нь дархлаажуулна.

4.2 Байгаль орчны нөхөн сэргээлт хийгээгүй аж ахуйн нэгжүүдийг хар жагсаалтад оруулж, уул уурхайн үйл ажиллагаа эрхлэх эрхийг нь тодорхой хугацаагаар хязгаарлаж, дахин шинээр хайгуулын болоод ашиглалтын тусгай зөвшөөрөл олгохгүй байна.

4.3 Аялал жуулчлалын салбарт үндэсний онцлогт тулгуурласан хөтөлбөрүүдийг боловсруулж олон улсын стандартыг төлөвшүүлэхэд хууль эрх зүйн орчны шинэтгэл хийнэ.

- Монголчуудын үүсэл гарвалын өлгий нутаг Орхоны хөндийг байгаль орчин, соёл, түүхийн өвийг төрийн хамгаалалтад авч, ногоон хөгжил, аялал жуулчлалын салбарын хөгжлийн тулгуур хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлнэ.
- Байгалийн унаган байдлыг хадгалах замаар тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлнэ.
- Монгол Улсын төрөөс аялал жуулчлалын талаар баримтлах бодлого үзэл баримтлалд Монгол угсаатны нүүдлийн соёл иргэншлийг шингээсэн 4 улирлын өнгө төрх үзэсгэлэнт түүх соёлын дурсгалт газар, археологийн олдвор, дэлхийд нэн ховордсон биологийн олон төрөл зүйл зэрэг давуу талуудыг зүй зохистой хослуулсан, гадаад дотоодын жуулчдын эрэлт хэрэгцээ сонирхолд нийцсэн аялал жуулчлалыг хөгжүүлэх.
- Гадаад дотоодын аялал жуулчлалыг нутгийн иргэдийн шууд оролцоонд тулгуурласан экологийн баримжаатай үзэл баримтлалыг Монгол улсын төрөөс аялал жуулчлалын талаар баримтлах бодлогын баримт бичигт тусган хэрэгжүүлнэ.



## **Тав . Аюулгүй байдал, гадаад харилцааны зорилт, хөтөлбөр**

5.1 Монгол Улсын гадаад бодлогын энх тайван, эв найрамдал, түншлэлийг эрхэмлэсэн уламжлалыг улам гүнзгийрүүлэн хөгжүүлнэ:

- Гадаад орнуудтай түншлэл хамтран ажиллах бүх хүрээнд үндэснийхээ эрх ашгийг найдвартай хамгаалан ул суурьтай хандах зарчмыг тууштай баримталж, нэгэнт харилцан тохиролцсон хүрээндээ найдвартай, хариуцлагатай түнш байх баталгаа бүрдүүлэх эрх зүй, зохион байгуулалтын нөхцөл бий болгоно.
- Хил залгаа хоёр хөрш оронтой харилцаа, хамтын ажиллагаагаа цаашид өргөтгөн хөгжүүлэхэд онцгой ач холбогдол өгч, хөрш тус бүртэйгээ харилцан ашигтай, тэгш хэмтэй, тэнцвэртэй, хөгжил дэвшилд чиглэсэн тогтвортой худалдаа, хамтын ажиллагаа эрхлэх чиглэл баримтална.

5.2 Гадаадын хөрөнгө оруулагчидтай гэрээ хэлцэл хийхдээ Монгол Улсын тухайн үеийн хууль тогтоомжийг зөрчсөн бүх үйлдлүүдийг нэн анхааралтай шинжлэн үнэлж, улс үндэснийхээ эрх ашгийг хохироосон актуудыг хүчингүй болгох буюу өөрчлөх, Монголын талаас ийм үйлдэл хийсэн хүмүүст хуулийн хариуцлага хүлээлгэх арга хэмжээ авна.

5.3 Улс орныхоо гадаад, дотоод орчин нөхцөлийг бодитой үнэлж, даяаршлын үед үндэснийхээ язгуур эрх ашгийг баталгаажуулан хамгаалахад чиглэсэн батлан хамгаалах бодлогоо халгапан упамжпуупна

- Насанд хүрсэн бүх эрэгтэйчүүд, цэргийн боловсрол олж, 18-45 насны эрчүүд 5 жил тутам улирлын цугларалтаар бэлтгэлээ сэргээх тогтолцоотой болох;
- Хилийн хамгаалалтыг мэргэжлийн цэрэг болон нутгийн иргэдийн хамтын ажиллагаанд тулгуурлан бататгах;
- Олон улсын энхийг сахиулах хүчний үйл ажиллагаанд оролцох мэргэшсэн цэрэг, офицеруудыг бэлтгэх тогтолцоог цаашид боловсронгуй болгон хөгжүүлэх;

## **Зургаа. Аж үйлдвэржилтийн бодлого**

6.1.1 Орон нутгийн байгалийн баялаг, түүхий эдэд түшиглэсэн үйлдвэрүүдийг төрөлжүүлэн хөгжүүлж нэгдсэн стандарттай болгох



6.1.2 Дэлхийн стандартад нийцсэн жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэхийн тулд паранченз оруулах

6.1.3 Хүнсний үйлдвэрийн бүтээгдэхүүнүүд үйлдвэрлэхдээ ард иргэдийн эрүүл мэндийг дэмжих нэмэлт витамин эрдсүүдээр баяжуулах.

6.1.4 Өрхийн үйлдвэрлэл эрхэлдэг, бичил үйлдвэрлэл эрхэлдэг ард иргэдийг дэмжсэн төсөл хөтөлбөр хэрэгжүүлж жижиг дунд үйлдвэрлэгч болгон хөгжүүлэнэ.

### **Долоо. Төсөв Мөнгөний бодлого**

7.1.1 Мөнгийг хэт шүтсэн сэтгэлгээг өөрчилнө

7.1.2 Төв банкны бодлогод өөрчлөлт хийж гадаадын мөнгө хүүлэгчдийг хязгаарлаж арилжааны банкууд, ББСБ, ХЗХ-ын хүүний дээд хязгаарыг хуулиар тогтоож өгнө.

7.1.3 Үндэсний мөнгөний үнэ цэнийг нэмэгдүүлж доллар төгрөгний харьцааг ойртуулна.

7.1.4 Бичил бизнесийг дэмжих сантай болно.

7.2 Төсөв

7.2.1 Төсвийн хөрөнгө оруулалтыг урт хугацааны бодлоготой уялдуулан хэмнэлттэй хариуцлагатай байхаар төлөвлөнө.

7.2.2 Гадаад өрийн даацыг багасгах замаар гадаадаас зээл авахгүй байх гарцыг олж өрийн дарамтгүй болно.

7.2.3 Төсвийн төлөвлөлтийг сайжруулж алдагдалгүй төсөвтэй болох

7.2.4 Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр авах бараа үйлчилгээг дотоодын аж ахуйн нэгж, үндэсний үйлдвэрлэгчдээс авдаг системийг хэвшүүлэх

